



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/467

Хэрлэн сум

Эвент арга хэмжээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Орон нутгийн байгаль, шинжлэх ухаан, түүх соёл, ахуй амьдрал, ёс заншил, онцлог шинжийг тусгасан тусгай баяр болох “Тогорууны баяр” эвент арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж 1,000,000 (нэг сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Ганбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ